


Мэдээллийн товхмол дугаар-3 (2023/10) Эко жолоодлогыг хэрэгжүүлж тээврийн хэрэгслээс үүдэлтэй асуудлыг сайжруулах арга хэмжээ-1



Эко жолоодлогын хяналтын
төхөөрөмжийг суурилуулсан байдал

Эко жолоодлогын төсөөлөл
Эх сурвалж: Байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах байгууллага (Япон)



Эко жолоодлогын тусламжтайгаар агаар бохирдуулагчийг бууруулах үр нөлөөг тодорхойлоход ашигласан тээврийн хэрэгслийн жишээ

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (JICA) Монгол дахь төлөөлөгчийн газар

Байршил: Shangri-la Centre, 19th and 21st Floor, 19A Olympic Street, Sukhbaatar District-1, Ulaanbaatar

Шуудан C.P.O.Box 682, Ulaanbaatar 15160, Mongolia

TEL: 976-7505-8778,

<https://www.jica.go.jp/overseas/mongolia/office/index.html>

Төслийн оффисын хаяг

c/o: DAAEP (Department of Against Air and Environmental Pollution of the Capital City)

1F, Khangarid Building, Khan-uul District, Artsat Naadamchid Road 1200, Ulaanbaatar

TEL: 976-11-314876

FAX: 976-11-318551

<https://www.aprd.ub.gov.mn/> <https://www.jica.go.jp/oda/project/1700340/index.html>

Эко жолоодлогын ерөнхий тойм

(1) Оршил

Эко жолоодлого бол автомашин жолооддог хүн бүр амархан шийдэж болох моторт нийгмийн янз бүрийн асуудлыг сайжруулах арга хэмжээний нэг юм. Тодруулбал, Хүснэгт 1-д заасан жолоодлогын 13 аргыг хэрэгжүүлж агаарын бохирдол, дэлхийн дулаарал зэрэг байгаль орчны хүндрэлийг бууруулж, зорчигч, зорчигчдын тав тухыг хангаж, зам тээврийн ослыг бууруулахаас гадна түлшний зарцуулалтыг хэмнэх зэрэг олон талын үр ашигтай байдаг.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2019 онд гаргасан шийдвэрийн дагуу нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөнд оролцохдоо стандартаас хэтэрсэн бохирдуулагч бодис ялгаруулж буй тээврийн хэрэгсэл, дизель хөдөлгүүртэй автобус, яндангийн шүүлтүүргүй ачааны автомашинуудын хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Зам тээврийн дэд сайд, Замын цагдаагийн газрын дарга нарт үүрэг болгож, дизель хөдөлгүүртэй автомашины бохирдлыг бууруулах арга хэмжээ болгож ЖАЙКА төслөөс эко жолоодлоготой холбоотой дараах ажлуудыг хийж байна.

- ① Ердийн жолоодлого болон эко жолоодлогын үеийн ялгаралд хэмжилт хийж, жолоодлогын мэдээллийг цуглуулж, Улаанбаатар хотод эко жолоодлогыг хэрэгжүүлснээр агаар бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах үр нөлөөг баталгаажуулна.
- ② Улаанбаатар хотын тээврийн хэрэгсэлд эко жолоодлогыг дэмжих төхөөрөмжийг суурилуулж, жолооч, үйл ажиллагааны менежерүүдэд эко жолоодлогын боловсрол олгоно.
- ③ Эко жолоодлогоор агаар бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах зорилгоор эко жолоодлогыг олон нийтэд түгээх сургалт сурталчилгааны ажлыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт-1: Эко жолоодлогыг бодитоор хэрэгжүүлэх аргачлал

No.	Агуулга
1	Огцом хааз өгөлгүй, зөөлнөөр хурд нэмэх (хааз зөөлөн гишгэх)
2	Хөдлөж эхлэх, хурд нэмэхдээ аргаагаа эрт шилжүүлж явах
3	Аль болох хөнгөн араагаар явах
4	Огцом хурд нэмж, хасахаас зайлсхийх
5	Хурд саарах үед хаазаа эрт суллаж, хөдөлгүүрийн тоормосыг ашиглах
6	Хангалттай хугацаатайгаар хурдаа хадгалж явах
7	Эйркондишны зохистой хэрэглээг хангах
8	Тодорхой хугацаагаар зогсох бол тээврийн хэрэгслийг унтраах шаардлагатай (хөдөлгүүр унтраах)
9	Тээврийн хэрэгслийн урсгал, замын ачааллыг шалгаж хөдөлгөөн оролцох
10	Дугуйн даралтыг тогтмол шалгах
11	Илүүдэл ачаанаас зайлсхийх
12	Бусдын хөдөлгөөнд саад учруулж зогсолт хийхгүй байх
13	Шатахуун зарцуулалтаа байнга хянаж хэвших

(2) Эко жолоодлогыг хэвшүүлэх

Энэхүү төсөлд батлагдаж, хэрэгжиж буй эко жолоодлогын утааны хийг бууруулах үр нөлөө, эко жолоодлогын боловсролын агуулгыг нийслэлийн иргэдэд өргөнөөр таниулж, Улаанбаатар хотын олон мянган жолооч нар эко жолоодлогыг хэвшүүлсэнээр тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлын ялгарал багасч, моторжуулсан нийгмийн янз бүрийн асуудлыг сайжруулах талаарх Улаанбаатарчуудын ухамсарыг нэмэгдүүлэхэд тус нэмэр болно гэж найдаж байна.

Улаанбаатар хотод эко жолоодлогыг хэвшүүлсэнээр агаар бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах үр нөлөө


Энэхүү мэдээллийн товхимолд 2021, 2022 онд Улаанбаатар хотод энгийн жолоодлого болон эко жолоодлогын үед АСХУХ-ээр хийсэн утааны хийн хэмжилтийн үр дүнг харьцуулж, эко жолоодлогын хэрэгжилтээс хүлээж болох үр дүнг харьцуулсан байдлаар нэг тээврийн хэрэгсэлд ногдох утааны хийг бууруулах үр нөлөөг үзүүлээ.

(1) Судалгааны маршрут болон ашигласан тээврийн хэрэгсэл


Судалгаанд энхтайвны өргөн чөлөөний дагуу хоёр талын зам, тойрог зам, нисэх онгоцны буудал руу чиглэсэн өндөр хурдны зам гэсэн гурван төрлийн маршрутыг сонгосон. Судалгаанд суудлын бензин хөдөлгүүртэй машин, хайбрид хөдөлгүүртэй машин мөн дизель хөдөлгүүртэй бага оврын ачааны машинуудыг ашигласан.

(2) Эко жолоодлогоор агаар бохирдуулах бодисын ялгарлыг бууруулах үр нөлөө


Эко жолоодлогыг хэрэгжүүлсний үр дүнд агаар бохирдуулах бодис бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлд NOx 12%-иар, түлшний зарцуулалт 3%-иар буурсан байна. Бензин хайбрид тээврийн хэрэгсэлд NOx 31%-иар, шатахуун зарцуулалт 2%-иар буурсан. Дизель хөдөлгүүртэй ачааны машины хувьд түлшинд агуулагдах хүхрийн агууламжийн хэмжээгээр NOx-ын ялгарал 13%-иар нэмэгдсэн байна.



Зураг 1 (1): Эко жолоодлогоор агаар бохирдуулагчийг бууруулах үр нөлөө (бензин тээврийн хэрэгсэл)



Зураг 1 (2): Эко жолоодлогоор агаар бохирдуулагчийг бууруулах үр нөлөө (бензин хайбрид)



Зураг 1 (3): Эко жолоодлогоор агаар бохирдуулагчийг бууруулах үр нөлөө (Дизель ачааны машин)

Эко жолоодлогын загвар төслийг цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөө

Энэхүү судалгаагаар эко жолоодлогыг хэрэгжүүлснээр энгийн жолоодлоготой харьцуулахад агаарт бохирдуулагч бодисын ялгарал буурч, түлшний хэмнэлт сайжирсан болохыг тодорхойлоо.

Одоогийн байдлаар эко жолоодлогын загвар төслийн хүрээнд нийслэлийн харьяа байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгсэлд эко жолоодлогыг дэмжих төхөөрөмжийг үргэлжлүүлэн туршиж, тээврийн хэрэгслийн жолооч, ашиглалтын менежерүүдэд эко жолоодлогын сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Түүнчлэн, эко жолоодлогыг дэмжих төхөөрөмж ашиглан энгийн жолоодлогын болон эко жолоодлогын үед жолоодлогын талаарх мэдээллийг цуглуулж, Улаанбаатар хотод эко жолоодлогыг хэрэгжүүлснээр агаар бохирдуулагчийн ялгаруулалтыг бууруулах үр нөлөөг бодитойгоор тооцож, эко жолоодлогыг дэмжих хууль тогтоомж, урамшууллын тогтолцооны бүрдүүлэхэд судалгааны материал болгохын зэрэгцээ, Улаанбаатар хотын иргэдэд ухуулан таниулж, жолооч нарыг эко жолоодлогод илүү анхаарал хандуулдаг болгоход хувь нэмэрээ оруулна гэж найдаж байна.

Энэхүү төслийн технологи дамжуулалт

- Улаанбаатар хотод эко жолоодлогыг нэвтрүүлж, агаар бохирдуулах бодисын ялгарлыг бууруулах үр нөлөөг АСХУХ-ээр хэмжиж үнэлнэ.
- Нийслэлийн харьяа байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэлд эко жолоодлогыг дэмжих тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, жолооч, үйл ажиллагааны менежерүүдэд эко жолоодлогын боловсрол олгох.



Энэхүү төслийн үр дүнгийн ашиглалт (төсөөлөл)

- Улаанбаатар хотын иргэд эко жолоодлогын үр нөлөөг хүлээн зөвшөөрч, жолооч нарыг эко жолоодлогыг дэмжсэнээр автомашинаас ялгарах хийг бууруулаад зогсохгүй, моторжуулсан нийгмийн олон асуудлыг шийдвэрлэх талаарх мэдлэг ухамсарыг дээшлүүлэхийг зорино.

Зураг 4: Эко жолоодлогын загвар төсөл хэрэгжүүлэлт